



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/562

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төслийн хүрээнд хэрэгжсэн багц 2 буюу ГААОНӨГ/202101008-2 дугаар гэрээт Тонхил сумын ариутгах татуургын төв шугам, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


Комиссын дарга:	А.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	З.Жаргалтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	М.Насанбат (Тонхил сумын Засаг дарга) (тохиролцсноор)
	М.Батсуурь (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн хяналтын инженер)
	Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Г.Золзаяа (Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

2.

- Д.Отгонжаргал (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
- Б.Батбилэг (Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
- Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
- Д.Байгальмаа ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ашиглалтын инженер)
- Л.Цогтбадрах ("Чанарын түншлэл" ХХК-ийн зөвлөх инженер) (зохиогч)
- Б.Эрхэмбаяр ("Ди Ди Эй Жи" ХХК-ийн архитектор) (зохиогч)
- Б.Батбаяр ("Жаргалант дулаан" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
- Нарийн бичгийн дарга: Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)

2.Барилга байгууламж, шугам сүлжээний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа техникийн комиссын дүгнэлт, гэрээнд тусгагдсан зураг төсөлтэй нийцүүлэн холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Тонхил сумын Засаг дарга (М.Насанбат), "Ундарга-Алтай" ААТҮГ (Б.Энхболд)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ